



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20²⁰ оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/123

Алтай хот

Үнэлгээний хороог шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Дэлгэр сумын шинээр баригдсан сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Батмагнай

Нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ

Гишүүд:

Ж.Мөнхчимэг

Б.Жигжээ

Ч.Ууганбаяр

-Байгаль орчин, аялал

жуулчлалын газрын дарга

-Орон нутгийн өмчийн газрын

худалдан авах ажиллагаа

хариуцсан мэргэжилтэн

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн

бодлого төлөвлөлтийн

хэлтсийн мэргэжилтэн

-Төрийн бус байгууллагын

төлөөлөл

-Есөнбулаг сумын иргэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Д.Батмагнай)-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гаргасантай холбогдуулан 2020 оны А/123 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001186